December
8-10th
2023

# MNCF

## Ice climbing festival & Competition

Nairamdal
international
Children's center

МУУХ /MNCF/ нь уулын спорт тэр дундаа хаданд авиралт, спорт авиралт, мөсөнд авиралтын төрлийг хөгжүүлэх, хүүхэд залуучуудын эв тэгш хүмүүжилд спортоор дамжуулан боловсрол олгох, олон нийтэд уулын спортыг таниулан сурталчилах зорилгоор 2022 оны 9 сард Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт Хадны фестивалийг амжилттай зохион байгуулсан билээ. Цаашлаад бид өвөл, зундаа уг фестивалийг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэ жил Мөсний фестиваль буюу Ice Festival 2023 оны 12-р сарын 8-10–ний өдрүүдэд өмнөх зорилгын хүрээнд зохион байгуулах гэж байна.

Улаанбаатар хотын **хамгийн өвөрмөц** спорт, соёлын арга хэмжээнд хамтран ажиллахыг ТА бүхнийг урьж байна.

**ХЭЗЭЭ, ХААНА: 2023.12.08-10 хооронд ОУ-ын Найрамдал хүүхдийн төв**









December
8-10th
2023

# MNCF

Ice climbing festival & Competition

Nairamdal
international
Children's center

## УБ ХОТЫН ХАМГИЙН ӨВӨРМӨЦ СПОРТ, СОЁЛЫН ФЕСТИВАЛ
## ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

### December 8th, Friday

- Нээлтийн үйл ажиллагаа: 17:30
- Movie Screening: The Scale of Hope 18:00 - 20:00

### December 9-10th, Saturday and Sunday

- OUTDOOR GEAR EXPO 08:00-16:00

Спорт болон авиралтын эдлэл, хэрэгслэлийн дэлгүүрүүд, хувь хүмүүсийн худалдаа

- Хүүхдийн авиралтын бүсэд чөлөөт авиралтууд 10:00-15:00
- Мөсөнд авиралт - Сонирхогчдын дундах хэсгийн авиралтын тэмцээн 09:00-13:00
- Техникийн авиралт - Сонирхогчдын дундах хэсгийн авиралтын тэмцээн 15:00-19:00




**ӨДРИЙН ТУРШИД**

- ХООЛ ХҮНСНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСАР
- АЯЛАЛЫН КЛУБУУДЫН АСАР
- БАЙГУУЛЛАГУУДЫН АСАР
- СПОРТ БАРАА ХУДАЛДААНЫ АСАР
- ХҮҮХДИЙН АВИРАЛТЫН БҮС
- АНХНЫ ТУСЛАМЖИЙН ХЭСЭГ

December
8-10th
2023

# MNCF

Ice climbing festival & Competition

Nairamdal
international
Children's center

## МӨСӨНД АВИРАЛТЫН ХАНА

## ТЕХНИКИЙН АВИРАЛТЫН /DRY TOOLING WALL/





## XKIDS CLIMBING WALL





## КЛУБУУДЫН АСАР

Баасан:
15:00 - 19:00 - 5 төслийн танилцуулга болон бүртгэл
Бямба
13:00 - 19:00 - 5 төслийн танилцуулга болон бүртгэл

**5 төсөл**

1. Цасны барс. 7000-с дээш 5 оргил.
2. Эверестийн үндсэн отог болон 6100 м дтд оргил.
3. 7 тивийн 7 оргил.
4. Цасны барс. (ОХУ). 5000 м дтд 10 оргил.
5. 8000-с дээш 14 оргил. 2025 онд Непалийн 7 оргил Хятадын 2 оргил.



## MORE INFORMATIONS

тун удахгүй ...

## ХАМТАРЧ АЖИЛЛАХ БУСАД БОЛОМЖУУД

## 1.GEOCACHING НУУВЧ ОЛОХ ТЭМЦЭЭН ИВЭЭН ТЭТГЭХ



12 сарын 8, 9, 10-ний өдрүүдэд нуувч олон тэмцээн болох бөгөөд нэг өдөрт олох нуувч 20-30 ширхэг байна. Энэхүү тэмцээний нуувчийг байгууллагын зүгээс өөрийн бүтээгдэхүүнээр дэмжин уг тэмцээнийг байгууллагын, брендийн нэрэмжит болгон явуулж хамтран ажиллах боломжтой.
Нуувч сонголтууд:
1.Нэг өдрийн нуувчийг гаргах /20-30 ш/
2.2 өдрийн нуувч гаргах /40-60 ш/

**Дэмжигч байгууллагад үзүүлэх үйлчилгээ, байгууллагын маркетинг**
**MNCF** арга хэмжээний үеэр баннер байршуулах, сошиал болон шууд цацагдах мэдээ мэдээллээр байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ, нийгмийн хариуцлагын
талаарх маркетингийг явуулах

## 2. ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

Худалдаа үйлчилгээ эрхлэх асар эзэмших - 500,000₮
Хоол хүнс борлуулах асар - 500,000₮






December
8-10th
2023

# MNCF

Ice climbing festival & Competition

Nairamdal
international
Children's center

## ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ХООЛ ХҮНСНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

















Холбоо барих: 9900-1415, 8809-3787

## 3. БАЙГУУЛЛАГА, БРЭНДИЙНХЭЭ ОНЦЛОГ ХАРУУЛСАН ОРЧИН БҮРДҮҮЛСЭН АСАР, ЗУРАГ АВАХУУЛАХ БҮҮТ, ТАЛБАЙГ ЧИМЭГЛЭЖ ОРОЛЦОХ














# 4. СОНИРХОГЧДЫН ДУНДАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

## MNCF ICE CLIMBING FESTIVAL AND COMPETITION 2023

| " МӨСӨНД АВИРАЛТЫН СОНИРХОГЧДЫН ТЭМЦЭЭН" |

### ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ

**СПОРТЫН ХОЛБОО:** "Монголын Уулчдын Үндэсний холбоо"
Ерөнхий нарийн бичгийн дарга: С.Ганхүү 99990884
Гүйцэтгэх нарийн бичгийн дарга: С.Даваабаяр 99001415
Цахим хаяг: info@mountain.mn
Хаяг: 409 тоот, Олимпийн хороо, Хан-Уул дүүрэг , Улаанбаатар 17011
Мөсөнд авиралтын хороон дарга: М.Цолмон 88093787
Цахим хаяг: tsolmonkarandash@gmail.com

**ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Тэмцээн болох хугацаа: 2023 оны 12 дугээр сарын 2-3
Тэмцээн болох газар: Улаанбаатар, Сонгино Хайрхан дүүрэг, 11-р хороо, Найрамдал Олон улсын Хүүхдийн цогцолбор төв

**БҮРТГЭЛ**: Тэмцээний бүртгэлийн систем 2023 оны 11 сарын 01-ны өдөр нээгдэж, 2023 оны 11 сарын 16-нд 23:59 цагт хаагдана.

**БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ**:

- Нэг төрөл 40.000 төгрөг
- Хоёр төрөл 60.000 төгрөг
- Хоцорсон бүртгэлийн хураамж үндсэн хураамжнаас 25 хувиар нэмэгдэнэ.

**ТӨРӨЛ:** Хурд, техник

**АНГИЛАЛ**:
Хурдны төрөл болон Техникийн авиралтын төрөлд:
- Залуучууд нас В ангилал – 15-17 нас /2006, 2007, 2008он/
- Залуучууд нас А ангилал – 18-20 нас /2003, 2004, 2005он/
- Насанд хүрэгчид – 21 дээш /2002 оноос өмнө/

Тэмцээнд оролцох багуудыг дараах бүрэлдэхүүн бүрэн оролцсон тохиолдолд багийн дүнгээр шалгаруулах жагсаалтанд оруулна. Үүнд:
- Залуучууд нас В ангилал: Эрэгтэй-1, Эмэгтэй-1
- Залуучууд нас А ангилал: Эрэгтэй-1, Эмэгтэй-1
- Насанд хүрэгчид: Эрэгтэй-1, Эмэгтэй-

1 Нийт: 6 тамирчин
Тэмцээнд тамирчид бие даан оролцож болох ба энэ тохиолдолд багийн дүнгээр шалгаруулах жагсаалтанд оруулахгүй.

**ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН**
Техникийн зөвлөгөөн 2023 оны 11-р сарын 25-ны өдрийн 20.00 цагт google meet цахимаар болох ба тухайн үед холбооны хуудсаар дамжуулан холбоосыг өгнө. Техникийн зөвлөгөөнд зөвхөн багийн дасгалжуулагч оролцоно.

**ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ:**

Тамирчид дараах багаж, хэрэгсэлтэй байх ба техникийн зөвлөгөөн буюу урьдчилсан шалгалтанд танилцуулна. Үүнд:
- Толгойн дуулга – тамирчин бүрт
- Худрага – тамирчин бүрт
- Крампон - тамирчин бүрт
- Мөсний алх /айс акс/ – багт хамгийн багадаа 2 хос
- Багийн туг /80 см * 50 см харьцаатай байх/ – 1 ширхэг

**ТЭМЦЭЭНИЙ БҮТЭЦ:**
Тэмцээнийг төрөл тус бүрт тамирчдын гарааг санамсаргүйгээр оноолт хийн жагсаана.
Хэсгийн болон шигшээ авиралтуудтай байна.
Хэсгийн авиралтнаас эхний 8 тамирчныг жагсааж шигшээ авиралтанд оруулна.
Тэмцээнийг дараах байдлаар дүгнэнэ. Үүнд:

- Хурд – Гараанаас бариа хүрэх урьдчилж заасан замыг туулсан хугацаагаар хэмжинэ.
- Техник – Гараанаас бариа хүрэх урьдчилж заасан замыг туулсан зай, даалгаварын гүйцэтгэл болон хугацаагаар хэмжинэ.
- Боулдеринг - Урьдчилж бэлтгэсэн замаар заасан хугацаанд багтаан олон удаагийн авирах оролдлого хийх ба бонус оноо, топ цэгт хүрсэн хугацаагаар хэмжинэ.

**ШҮҮЛТ:**
- Тэмцээнд Ерөнхий шүүгч -1, Техникийн шүүгч -2, Нарийн бичиг шүүгч-1, Оролцогчдын дэргэдэх шүүгч –1 , Хамгаалагч шүүгч -2, камерийн шүүгч -1, цагчин шүүгч -2 гэсэн нийт 10 бүрэлдэхүүнтэй шүүгчид ажиллана.
- Тэмцээнийг МУУХ-ны Удирдах зөвлөлөөс баталсан дүрмийн 2-р бүлэгт заасны дагуу МУУХ-ны Шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон шүүгчид шүүнэ.

**МАРГААН ТАСЛАХ, ШИЙДВЭРЛЭХ**

- Тэмцээний шүүлт болон дүрэм зөрчигдсөн маргаантай асуудлыг бичгээр үйлдэж, тэмцээний Нарийн бичиг шүүгчид бичгээр гомдол гаргана.
- Авиралт хийснээс 30 минутын дотор багийн дасгалжуулагч эсвэл ахлагч гомдол гаргах эрхтэй.
- Гомдол гаргагч 100,000 төгрөгийн барьцаа тавьж гомдлоо бичгээр гаргах ба хэрэв гомдол үндэслэлтэй гэж үзвэл уг барьцааг буцаан олгоно.
- Гаргасан гомдол нотлогдохгүй бол уг барьцаа Тэмцээн зохион байгуулах ажлын хэсэгт үлдэнэ.
- Тэмцээний маргаан таслах комисс нь Холбооны шүүгчдийн зөвлөл байна.
- Нарийн бичиг шүүгч гомдлыг хүлээж авахдаа гомдол гаргасан хүний гарын үсэг, хүлээн авсан цаг минутыг заавал бичих ба маргаан таслах комиссын гишүүдийг цуглуулан асуудлыг шийдвэрлүүлнэ.

**ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

- Тэмцээний туршид ажиллах эмчийг Холбооны Эрүүл мэндийн хороо томилно.
- Анхны яаралтай тусламжийг Эрүүл мэндийн хорооноос томилсон мэргэжлийн /гэмтлийн/ эмч үзүүлэх ба Тэмцээн зохион байгуулах ажлын хэсгээс дэмжлэг үзүүлнэ.

**АЮУГҮЙ БАЙДАЛ:**
- МУУХ нь тэмцээнд хэрэглэгдэж буй техник хэрэгсэл, байгууламжийн аюулгүй байдлыг ханган ажиллана.
- Тамирчин нь өөрийн хэрэглэж буй тоноглол (толгойн дуулга, хударга, кранпон, мөсний алх) аюулгүй байдлыг хангана.
- Тамирчид аюулгүй байдлаа хангаж даатгал хийлгэсэн байж болно.

**ЁС ЗҮЙ, САХИЛГАНЫ ЖУРАМ**

Тамирчин, дасгалжуулагч, багийн гишүүдийн спорт бус зан харилцаа, үйлдэл гаргах тохиолдолд Олон улсын спорт авиралтын холбооны ёс зүй, сахилганы журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ёс зүй, журмыг тамирчдад урьдчилан танилцуулна.

## 5. ЗАРДАЛ, ТӨСӨВ - нийт зардал 48,000,000₮

### ХҮҮХДИЙН АВИРАЛТЫН ХАНА /5-12 НАС/

**6,000,000₮** АВИРАЛТЫН ХАНА БАРИХ ЗАРДАЛ












December
8-10th
2023

# MNCF

Ice climbing festival & Competition

Nairamdal
international
Children's center

## МӨСӨНД АВИРАЛТЫН ХАНА

**12,000,000₮** АВИРАЛТЫН ХАНА БАРИХ ЗАРДАЛ











December
8-10th
2023

# MNCF

Ice climbing festival & Competition

Nairamdal
international
Children's center

## ТЕХНИКИЙН АВИРАЛТЫН ХАНА

**22,000,000₮**

**АВИРАЛТЫН ХАНА БАРИХ ЗАРДАЛ**











December 8-10th 2023

# MNCF

Ice climbing festival & Competition

Nairamdal international Children's center

## 2 ТӨРӨЛД 90 МЕДАЛЬ + ШАГНАЛЫН САН

**8,000,000₮**

**ТӨРӨЛ:** Хурд, техник

**АНГИЛАЛ**:

Хурдны төрөл болон Техникийн авиралтын төрөлд:

- Залуучууд нас B ангилал – 15-17 нас /2006, 2007, 2008он/
- Залуучууд нас A ангилал – 18-20 нас /2003, 2004, 2005он/
- Насанд хүрэгчид – 21 дээш /2002 оноос өмнө/

Тэмцээнд оролцох багуудыг дараах бүрэлдэхүүн бүрэн оролцсон тохиолдолд багийн дүнгээр шалгаруулах жагсаалтанд оруулна. Үүнд:

- Залуучууд нас B ангилал: Эрэгтэй-1, Эмэгтэй-1
- Залуучууд нас A ангилал: Эрэгтэй-1, Эмэгтэй-1
- Насанд хүрэгчид: Эрэгтэй-1, Эмэгтэй-

1 Нийт: 6 тамирчин

Тэмцээнд тамирчид бие даан оролцож болох ба энэ тохиолдолд багийн дүнгээр шалгаруулах жагсаалтанд оруулахгүй.

## ХОЛБОО БАРИХ:

**СПОРТЫН ХОЛБОО:** "Монголын Уулчдын Үндэсний холбоо"

Ерөнхий нарийн бичгийн дарга: С.Ганхүү 99990884

Гүйцэтгэх нарийн бичгийн дарга: С.Даваабаяр 99001415

Цахим хаяг: info@mountain.mn

Хаяг: 409 тоот, Олимпийн хороо, Хан-Уул дүүрэг , Улаанбаатар 17011

Мөсөнд авиралтын хороон дарга: М.Цолмон 88093787

Цахим хаяг: tsolmonkarandash@gmail.com